



ОРХОН СУМЫН АРДЧИЛСАН  
НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.09.30 № 037-2020/04-НА-27  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Орхон сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Орхон сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020619


## Дүгнэлт

Орхон сумын Ардчилсан намын хорооны Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхон сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр /... хуудас /-ийг хавсаргав.


Хувийг: Орхон сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ОРХОН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**Аж үйлдвэр**

1. Ахуйн хог хаягдлыг ангилан хаях менежментийг сайжруулж айл өрх, албан байгууллагатай хамтран ажиллана.
2. Бизнес эрхлэгчид болон баялаг бүтээгчдийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

**Хүнс хөдөө аж ахуй**

3. Малын үүлдэр угсааг сайжруулж, Орхон үүлдрийн хонины эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
4. Нийтийн эзэмшлийн худгийг ухаалаг системтэй болгож, зөөврийн усан сантай худгийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
5. Газар тариалангийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана.
6. Малчдын бэлчээрт ойрхон тариалангийн талбайг тусгаарлах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж, тариалангийн талбайг хашлага, хаалттай болгоход холбогдох байгууллага, иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллана.
7. Төмс, хүнсний ногооны хөтөлбөр боловсруулж, борлуулалтыг нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжинэ.
8. Гахай, шувуу, зөгий, загас болон бусад туслах аж ахуйг өрх, фермерийн аж ахуйн түвшинд эрхлэхийг дэмжиж ажиллана.
9. Өвөл, зуны хүлэмж барих, иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.

**Дэд бүтэц, аялал жуулчлал**

10. “Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлж өрх бүрийг ногоон байгууламжтай болох нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
11. “Хашаандаа сайхан амьдаръя-2” төслийг хэрэгжүүлж гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах замаар сумын иргэдийн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.
12. Сумын нийтийн эзэмшлийн зам талбайг камержуулах ажлыг эхлүүлж, иргэдийн ая тухтай, аюулгүй орчинг бүрдүүлнэ.


**Эрүүл мэнд**

13. Эрүүл мэндийн даатгалаас олгогддог эмийн хөнгөлөлтийг тэгш, хүртээмжтэй олгох асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
14. Иргэн бүрийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, хөдөөгийн айл өрхүүдэд явуулын тусламж үйлчилгээг үзүүлэхийг бодлогоор дэмжиж ажиллана.
15. Эх, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тэдэнд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

**Боловсрол**



16. Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн оюун ухааны спортыг эхлүүлж, тамирчдыг аймаг, улсын чанартай тэмцээнд оролцох ажлыг бодлогоор дэмжинэ.
17. Шилдэг багш, суралцагчдыг гадаад, дотоодын сургуулиудад суралцуулах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
18. Улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцож буй хүүхэд, залуучуудыг бодлогоор дэмжин ажиллана.



#### **Хөдөлмөр эрхлэлт**

19. Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллана. Ажлын байр шинээр бий болгоно.
20. Зорилтот бүлэг болон амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой иргэдийг тэргүүн эгнээнд ажлын байраар хангахыг бодлогоор дэмжиж ажиллана.

#### **Засаглал**

21. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэр, сонгон шалгаруулалт, зарцуулалтыг ил тод, цахим болгоно.
22. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж ажиллана.

Орхон сумын Ардчилсан намын хороо

